

## ШИНЖЛЭХ УХААНЫ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

### МОНГОЛ СУДЛАЛЫН ХОС БАГАНА

Эдүгээ цагийн Монгол судлал, нэн ялангуяа монгол хэл бичгийн ухааныг манлайлан түүчээлэгч хэмээн зүй ёсоор өргөмжлөгдөн хүндлэгдсэн их эрдэмтэд бол Далад овогт Далантайн Цэрэнсодном, Бичээч овогт Домийн Төмөртоого нар мөн. Хоёулаа хамтдаа эдүгээгээс 60 жилийн тэртээ өмнө 1957 оны намар МУИС-ийн Монгол хэл, утга зохиолын ангид элсэн оржээ. Хоёулаа адилхан монгол хэл бичгийн шинжлэх ухааны доктор, хоёулаа ижилхэн их сургуулийн профессор. Хоёулаа хамтдаа 1998 онд Монгол улсын ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогджээ. Хоёулаа адилхан Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн юм. Монгол хэл бичгийн ухаанд

шинжлэх ухааны шинэ чиглэлийг үүсгэсэн салгахын аргагүй адилхан, ялгахын аргагүй ижилхэн их эрдэмтэд билээ. Нэг нь монгол ардын аман болон бичгийн утга зохиол судлалын чиглэлээр газрын цээжинд хэдийнээ өнгөлөн гарсан бол нөгөө нь монгол хэл шинжлэлийн чиглэлээр дэлхийд нэрд гарсан их эрдэмтэн мөн. Хоёулаа ижилхэн өөрсдийн дурсамжаа “Өгсүүр замын дурсамж”, “Өгсүүр замаар” гэж бараг л адилхан нэрлэжээ. Эдүгээ хоёулаа Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хурээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар мөр зэрэгцэн амжилттай ажиллаж байна.



*Академич Д.Төмөртоого, Академич Д.Цэрэнсодном нар*

## ДАЛАД ОВОГТ ДАЛАНТАЙН ЦЭРЭНСОДНОМ

Академич Д.Цэрэнсодном багш маань 1937 оны наадмын дараахан 7 дугаар сарын 15-ны өдөр Сүхбаатар аймгийн Халзан сумын долдугаар багийн нутаг “Арбулаг” хэмээх газар малчин ард Далантайн гэрт төржээ. Багадаа өвөг эцгийнхээ гар дээр өсч торниод Сүхбаатар аймгийн төвийн арван жилийн дунд сургуульд суралцаж 1957 онд төгсөөд, МУИС-ийн монгол хэл, утга зохиолын ангид элсэн суралцаж, 1962 оны зун монгол хэл, уран зохиолын багшийн мэргэжил эзэмшин төгсчээ.

Д.Цэрэнсодном 1962 оноос эдүгээ хүртэл Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд л эрдэм шинжилгээний дэд, ахлах, тэргүүлэх ажилтнаар нийтдээ 55 жил тасралтгүй ажиллаж байна.

Судлаач Д.Цэрэнсодном 1972 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнд хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг, 1983 оны 7 дугаар сарын 7-ны өдөр БНАГУ-ын Гумбольдтын нэрэмжит Их сургуульд “XIII-XIV зууны үеийн монгол яруу найргийн өв” (онол, түүхийн судлалаар) хэмээх эрдэм шинжилгээний ганц сэдэвт бүтээлээрээ хэл бичгийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Хэл бичгийн шинжлэх ухааны доктор Д.Цэрэнсодном 1974-1978 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Утга зохиолын секторын эрхлэгчээр ажиллаад, 1978-1979 онд Герман улсад хоёр академийн хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу Берлин хотын Турфаны цуглуулгын Монгол бичгийг хамтран судлах ажилд үндсэн зохиогчоор оролцжээ. Түүнчлэн 1988-1990 онд БНХАУ-ын Бээжин их сургуульд монгол хэлний зочин багшаар уригдан ажиллах үедээ “Монголын нууц товчооны эрдэм шинжилгээний орчуулга тайлбар” гэсэн судалгааны томоохон бүтээл бичиж туурвисан гэдэг.

Академич Д.Цэрэнсодном “XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр” (1969),



*Академич Д.Цэрэнсодном*

“Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал” (1978), “Монгол уран зохиол” (XIII-XX зууны эхэн) [1987, 2002], “Турфаны цуглуулгын монгол бичиг” (1993), “Монголын нууц товчооны эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар” (1993), “Бурхан багшийн арван хоёр зохионгуйн тайлбар” (1997), “Монголын бурханы шашны уран зохиол”, I, II дэвтэр (1997, 2007), “Монголын уран зохиолын товч түүх” (2002), “Монголын нууц товчооны сонгомол эх” (2005), “The Biography of Chakar Gebshi Lubsangtsultim, Treasures of Mongolian Culture and Tibeto-Mongolian Buddhism” (2007), “Төр ёсны есөн сацал” (2007), “Монгол эм домын засал” (2007), “Монгол аман зохиолын судалгаа” (2009), “Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг” (2011), “Туульч Цагаадайн Зодовын хайлсан туулиуд” (2016), “Бичгийн хүмүүний бийрийн увдис” (2017), мөн их, дээд сургуулийн оюутан, багш нарын гарын авлага болгож “Монгол ардын аман зохиолын дээж бичиг” (1967), “Монголын уран зохиолын тойм”-ын II, III дэвтэр (1976, 1968)-г голлох зохиогчоор оролцжээ. Тэрчлэн “Монгол ардын үлгэр”, “Монгол домог үлгэр”, “Сургаал үгсийн охь”, “Өв соёл” тэргүүтэн товхимол хэвлүүлсэн агаад “Турфаны цуглуулгын монгол шүлэг”, “Монгол шүлгийн тухай”, “Нууц товчооны доторх домгийн сэтгэлгээний ойлголт”, “Чингис гэдэг нэрийн учир”, “Эрдэнэ

догшин ноён хутагтын эш үзүүлсэн нэгэн сургаал” зэрэг эрдэм шинжилгээний онол, хэрэглээний ач холбогдол бүхий судалгааны 50 гаруй ганц сэдэвт зохиол, сурах бичиг, хамтын бүтээл; 300 орчим эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, шүүмж, тэмдэглэлийг дотоод, гадаадад нийтлүүлж, өргөн олны хүртээл болгожээ. Түүний ном зохиол, өгүүллүүд нь англи, герман, орос, солонгос, унгар, франц, хятад, япон хэлээр орчуулагдсан байна. Монгол ардын аман зохиол, монголын уран зохиолыг сурвалжлан цуглуулж, судлан шинжлэх нүсэр их ажлыг академич Д.Цэрэнсодном 60 жил хоёргүй сэтгэлээр тууштай агаад үр бүтээлтэй хийж иржээ. Монгол аман зохиол, бичгийн утга зохиолын түүхийг их дээд сургуульд олон жил зааж, лекц уншиж, тусгай ном, сурах бичиг эмхэтгэн гаргасан

нь ахин дахин хэвлэгдэж, мянга мянган оюутан залуус, мэргэжлийн эрдэмтдийн чухал гарын авлага болсоор байгааг онцлон тэмдэглэлтэй.

Дэлхийн улс түмний уран зохиолын алтан сан хөмрөгт аль хэдийнээ хүндтэй байр сууриа эзэлсэн “Монголын нууц товчоон”-ы судалгаа, орчуулга, тайлбарыг манай эрдэмтэд эртнээс сонирхон оролдсон билээ. XX зууны эхэн үеийн Баргын Цэнд гүнтний 1917 оны хамгийн анхны монгол орчуулга сийрүүлэг, академич Ц.Дамдинсүрэнгийн орчин цагийн монгол хэлнээ бүрэн төгс яруу сайхан буулгаж 1947 онд хэвлүүлэн Монгол улсын Төрийн шагнал хүртсэн анхны уран сайхны иж орчуулга гарчээ. ЮНЕСКО-ийн шийдвэр 1990 онд гарч “Монголын нууц товчоон” зохиогдсоны 750 жилийн түүхэн ойг дэлхийн дэвшилт хүн төрөлхтөн нийт даяар тэмдэглэх болсон нь эрдэмтэн мэргэдийн судалгаанд үнэхээр урам хайрласан хэрэг явдал болжээ. Ялангуяа Олон улсын

монголч эрдэмтдийн V их хурлын үеэр 1987 онд энэ асуудал анхлан сөхөгдөж ШУА-ийн дэргэд “Монголын нууц товчоон” судлалын ажлын хэсэг байгуулагдсан нь их түлхэц, сайхан боломж өгсөн юм. Энэхүү ашдын буянтай үйл хэрэгт доктор Д.Цэрэнсодномын “Монголын нууц товчооны орчуулга тайлбар” хэмээх бүтээл жинтэй хувь нэмэр оруулсан. Энэхүү



*Академич Д.Цэрэнсодном, академич Ц.Дамдинсүрэн, профессор Д.Цэнд нар*

бүтээл бол академич Ц.Дамдинсүрэнгийн уран сайхны орчуулга, профессор Ш.Гаадамбын сэргээсэн эх тайлбараас арга зүй, зарчмын хувьд нэлээн ялгавартай бөгөөд тэр нь эрдэм шинжилгээний эхийн орчуулга болсноор юуны өмнө тодорхой илэрдэг. Ингэхдээ голлон баримталсан зарчим нь “Монголын нууц товчоон”-ы нанхиад уг галиг эхийг ягштал баримталж, ганц ч үг орхихгүй нэмэхгүйгээр, өнөөгийн уншигчдад ойлгомжтой үг хэллэгээр буулгахыг хичээсэнд оршино. Уг бүтээл нь 1990 онд “Цог” сэтгүүлийн цувралаар уншигчиддаа анхлан хүрсэн түүхтэй юм. Үүний зэрэгцээгээр хуучирсан 700 гаруй үг хэллэгийн судалгааны тайлбар хийж хавсаргасан нь өнөөгийн уншигчдад зөв ухаарч ойлгоход нь зүг чиг болж тусалсан, эх зохиолын үгийн сангийн судлалд үнэ цэнтэй, үүрдийн буянтай ажил болжээ. “Монголын нууц товчоон”-ы судлалд уламжилж ирсэн зөвхөн хятад хадмал орчуулга, зүйл бүрийн

төгсгөл дэх хураангуй хятад орчуулгыг баримтлан монголын нутгийн аялгууны эх хэрэглэгдэхүүн, эртний монгол хэлний дурсгалуудтай уялдуулан судлах нь туйлын дутагдалтай буюу эсвэл хятад хэл мэдэхгүй учир Мин улсын үеийн хадмал орчуулгыг бүрэн ашиглаж чадаагүй доголдлыг огоорч, авах гээхийн ухаанд шүтсэн нь уг бүтээлийн үнэ цэнийг улам ч өргөдөг.



*Академич Д.Төмөртоогоо, гавэж Ш.Сонинбаяр, академич Д.Цэрэнсодном, профессор Ч.Хишигтогтох нар*

Тэрбээр “Монголын нууц товчоон”-ы судлалаар 2008 онд “Монголын нууц товчооны утга зүй, уран сайхны шинжилгээ” хэмээх судалгааны бүтээл нийтлүүлснээс гадна “Дува сохорын домог, ганц нүдэт аварга амьтны тухай өгүүлэмжтэй холбогдох нь” (1983), “Пословицы и поговорки в Сокровенном сказании” (1986), “Некоторые мифологические представления в Сокровенном сказании монголов” (1986), “Монголын нууц товчооны домгийн сэтгэлгээний зарим нэгэн ойлголтын тухай” (1987), “Об этимологии одного из выражений Сокровенного сказания монголов” (1987), “Генелогическая связь предания о Дове Сохоре с мифлогическим сюжетом одноглазого великана” (1987), “Монголын нууц товчооны эртний онгон шүтээний тухай ойлголт” (1988), “Нууц товчооны

орчин цагийн монгол хэлний хэдэн хөрвүүлгийн тухай” (1994), “Монголын нууц товчоон дахь бөө мөргөлийн домгийн ойлголт” (1999), “Монголын нууц товчооны хятад хадмал орчуулгад орхигдсон үг хэллэгийн учир” (2000), “Монголын нууц товчооныг хожуу үеийн зарим түүхэн сурвалжтай харьцуулан судлахын ач холбогдол” (2003), “Монголын нууц товчоон хийгээд “Чингис хааны шар дэвтэр”-ийн учир холбогдлын тухайд” (2004), “Монголын нууц товчоон дахь онгон шүтээний тухай ойлголт” (2006), “Монголын нууц товчоон дахь “малгайн баули” хэмээх үгийн утга учир” (2007), “Академич Ц.Дамдинсүрэнгийн “Монголын нууц товчоон”-ы орчуулгын онцлог” (2008), “Монголын нууц товчоон”-ы бичвэр судлал” (2010) зэрэг эрдэм шинжилгээний сонирхолтой олон өгүүлэл, илтгэл бичжээ.

Академич Д.Цэрэнсодном Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн “Монголын нууц товчоон” судлалын төвийг 2004 онд үүсгэн байгуулсны зэрэгцээ Монгол улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн зарлигаар Монгол улсын Төрийн хүндэтгэлийн өргөөнд залах Монголын бичмэл түүхэн сурвалжийн хамгийн анхны дээж бичиг болох “Монголын нууц товчоон”-ы сонгомол эхийг сэргээн боловсруулах ажлын хэсгийг удирдан ажиллаж, сонгомол эхийг нийтлүүлж, айл бүрийн өргөө гэрийн хойморт залсан билээ. “Монголын нууц товчоон”-ыг Д.Цэрэнсодном багш маань “Монгол төрийн нууц түүх” гэж нэрлэдэг.

Академич Д.Цэрэнсодномын олон жилийн эрдэм шинжилгээний үйл хэрэг, ажил хөдөлмөр, бүтээл туурвилыг нь Монгол улсын төр засгаас өндрөөр үнэлж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон (1997), Монгол улсын Төрийн шагнал (1998), “Шинжлэх ухааны тэргүүний

ажилтан” (1999) цол, Монгол улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн (2007) цол хүртээжээ. Мөн 2015 онд Олон улсын алтай судлалын байнгын бага хурал (PIAC) [Permanent International Altaistic Conference]-ийн Алтан медаль хүртжээ. 1965 онд энэхүү хүндтэй шагналыг академич Б.Ринчен (1905-1977) Монгол улсаас анхлан хүртсэнээс 50 жилийн дараа ийнхүү Д.Цэрэнсодном багшид олгосныг

сайшаан тэмдэглэе.

Ардын уран зохиолч, туульч өөлд Тангадын Галсан 1998 онд тэрлэн бичиж ШУА-ийн “Эрдэм” сонин (1998 оны хоёрдугаар сар, № 3)-д нийтлүүлсэн “Эрдэмтдэд өргөх инээдмийн хадаг” хэмээх нөхөрсөг шогийнхоо академич Д.Цэрэнсодномд тусгайлан зориулсан хэсэгт:

*Үхэр жил академич болсон  
Үнэн хүчит “аварга” Цэрэнсодномын цолыг  
Монгол улсын бөхийн засуул  
Лонцойдорж дуудваас:  
Дарьгангын сайн эрийн удам  
Дагз магнай нь таван төө уудам  
Дар-Алтан овоонд даяан хийсэн лам  
“Данжуур”, “Ганжуур”-ын далайг гаталсан “тулам”  
Да багшийнхаа дутууг гүйцээсэн эрдэм  
Далайн амьтнаар бол нас гүйцсэн халим  
Далантайн хүү Цэрэнсодном=Сод+ном*

хэмээн элэглэл шүлэг бичиж зохиосон байдгийг дурдалтай.



*Академич Далантайн Цэрэнсодномыг*

*Олон улсын Алтай судлалын байнгын бага хурал (PIAC)-аас Алтан медалиар шагналаа.*

Академич Д.Цэрэнсодном нь шинжлэх ухааны байгууллагад олон жилийн турш үр бүтээлтэй ажиллаж, монголын уран зохиол, монгол ардын аман зохиолын төрөл зүйлийг дагнан судалж, эрдэм шинжилгээний чухал нээлт дүгнэлт хийхийн зэрэгцээ олон тооны ном бүтээл, сурах бичиг бичиж туурвисан эрдэмтэн юм. Тэрбээр ахмад эрдэмтдийн залуу халааг бэлтгэхэд онцгой

анхаарч, олон арван гарын шавь төрүүлж, “Монголын бурханы шашны уран зохиол”, “Монголын нууц товчоон судлал”-ын чиглэлээр дорвитой олон бүтээл туурвин бичсэний дээр монгол ардын аман зохиол, монгол зан заншил, монгол утга соёлыг хойч үедээ өвлүүн үлдээх, дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан нэрт эрдэмтний нэг мөн билээ.



*Академич Д.Төмөртоого*

## БИЧЭЭЧ ОВОГТ ДОМИЙН ТӨМӨРТОГОО

Академич Домийн Төмөртоого багш 1938 оны хавар, нар тоссон говь нутаг - Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Элсэн хошуу” хэмээх газарт тэмээчин ардын гэр бүлд төржээ. Тэрбээр 1947-1951 онд Ханбогд сумын бага сургууль, 1951-1954 онд Цогтцэций сумын дунд сургууль, 1954-1957 онд Өмнөговь аймгийн төвийн 10 жилийн дунд сургуульд суралцан төгсөөд, улмаар 1957-1962 онд МУИС-ийн Монгол хэл, утга зохиолын ангид суралцан дүүргэжээ.

Академич Домийн Төмөртоого багш 1961-1963 оны хичээлийн жилд Өмнөговь аймгийн төвийн 10 жилийн дунд сургуульд нэг жил багшаар ажиллаад, 1963-2004 онд дөчин хоёр жил Улсын Багшийн Дээд Сургуульд монгол хэлний багш, профессор, эрдэм шинжилгээ - гадаад харилцаа эрхэлсэн дэд захирлаар ажиллаж байгаад, 2004 оноос Монгол Улсын Их Сургуулийн Монгол судлалын төвийн захирал, 2007 оноос Монгол улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажиллаж байна.

Хэл бичгийн шинжлэх ухааны доктор Д.Төмөртоогогийн нийтлүүлсэн танин мэдэхүйн ач холбогдолтой сурталчилгааны анхны бүтээл нь 1962-1963 оны хичээлийн жилд төрсөн нутаг Өмнөговь аймгийн төвийн 10 жилийн дунд сургуульд монгол хэлний багшаар орон нутагт ажиллаж байхдаа тэрлэн бичсэн “Орос дахь монгол хэл, утга зохиолын судлал”, “ЗХУ дахь монгол хэл, утга зохиолын судлал” гэсэн цуврал хоёр өгүүлэл болно. Хойд хөршийн монгол судлалын ололт амжилтын тухай товч мэдээлсэн энэхүү хоёр өгүүллээ Өмнөговь аймгийн “Говийн мэдээ” сонин 1962 оны XI сарын № 83, 84 дүгээрт нийтлүүлж байжээ.

Монгол хэл бичиг судлаач Домийн Төмөртоого багш 1990 онд “Монгол хэлний төлөөний нэрийн гарал, тогтолцоо”

хэмээх сонирхолтой сэдвээр хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг амжилттай хамгаалсан. Эрдмийн зөвлөлийн зарим гишүүд хэл бичгийн ухааны докторын зэрэг хүртээх санал гаргаж байсан юм. Энэхүү эрдмийн зөвлөлийн хурлын ном хаялцаанд хэл бичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Чой.Лувсанжав (1930-1998) багш оролцож “Хэл зүйн цөм нь төлөөний нэр байдаг. Д.Төмөртоого судалгаандаа нэгэн талыг биш олон талыг барьж, хам цуваа цагийн үүднээс биеийн төлөөний үгийг судалж, олон маргаантай асуудлыг нэг мөр болголоо. Судалгаанд холбогдох бүхий л эх хэрэглэгдэхүүнийг шавхан үзэж, суурь судалгааны төвшинд хүртэл судлан дүгнэжээ. Дунд үеийн монгол хэлний дурсгалт бичгүүдийг судлах талаар Америкийн эрдэмтэн Ф.В.Кливез (1911-1995)-ийг гүйцэх хүнгүй гэдэг. Тэгвэл одоо УБДС-ийн багш Д.Төмөртоого гүйцэгдэхгүй боллоо. Академич Ш.Лувсанвандан (1910-1983) багшийг залгамжлах хүнтэй боллоо. Түүний шавь Д.Төмөртоого бол аль хэдийнээ эрдэмтэн болсон хүн. Өнөөдрийн зэрэг хамгаалж байгаа бүтээл нь дэд эрдэмтний биш, докторын зэрэгт тэнцэхээр болжээ. Дэлхийд гайхуулах эрдэмтэнтэй болсондоо Монгол улс бахархах ёстой” гэж ихэд өндрөөр үнэлэн хэлж байсныг онцлон дурдалтай.

Профессор Д.Төмөртоого багш монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал,

түүхэн хэл зүй, түүхэн авиа зүй, сурвалж бичиг судлал, эх бичиг судлалаар дагнан мэргэшиж, эрдэм шинжилгээний хэдэн арван бүтээл бичиж хэвлүүлсэн юм. Тэрбээр “A Modern Mongolian - English - Japanese Dictionary” (1979), “Монгол хэлний биеийн төлөөний нэрийн гарал, хувьсал” (1990), “Монгол хэлний түүхэн хэл зүйн үндэс” (Монгол хэлний түүхэн авиа зүй) [1992], “Монгол хэл шинжлэлийн онол, түүхийн асуудлууд” (2002), “Монгол дөрвөлжин үсгийн дурсгалын судалгаа” (2002), “Араб үсгийн монгол дурсгалын судалгаа” (2002), “Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны хураангуй толь” (2004), “Монголын нууц товчоон” [сонгомол эх] (2005), “Mongolian Monuments in Uigur-Mongolian Script” [XIII-XVI centuries] (2006), “Монгол хэлний биеийн төлөөний нэрийн гарал, бүтэц, тогтолцоо” (2008), “Mongolian Monuments in Phagspa Script” (Introduction, Texts, Transcription and Bibliography) [2010], “Монгол хэлний бичгийн дурсгалуудын үгийн бүтцийн харьцуулсан судалгаа” (2011), “Монгол хэлний үгийн бүтцийн толь” (2014), “Хубилай хааны зарлигууд” (2015), “Монгол хэлний түүхэн судалгааны удиртгал” (2015), “Хэл шинжлэлийн монгол-англи толь бичиг” (хамтын бүтээл) [2016] тэргүүтэн хорь гаруй ном, ганц сэдэвт бүтээл, толь бичиг; “Монголын соёл” (1965), “Алтайн хэл ба монгол хэл” (1978), “Орчин цагийн монгол хэлний урт эгшгийн гарал, хувьсал” (1980), “Монгол бичгийн хэл” (1983), “Монгол хэлний хос эгшгийн гарал, хувьсал” (1985), “Монгол хэлний сурах бичиг” [хамтын бүтээл] (1998), “Монголын соёлын түүх” [хамтын бүтээл] (1999), “Монгол хэл шинжлэл. Ш.Лувсанвандан” [хамтын бүтээл] (2006) зэрэг арав гаруй гарын авлага, товхимол; нийтдээ наяд орчим эрдэм шинжилгээний

өгүүлэл туурвиж нийтлүүлжээ. Эрдэм шинжилгээний бүтээлийн нэлээд нь Англи, Герман, Канад, Солонгос, Тайвань, Турк, Хятад, Энэтхэг, Япон зэрэг орны эрдэм шинжилгээний цуврал, сэтгүүлд хэвлэгдэн гарчээ. Түүний эрдэм шинжилгээний бүтээл бүр нь урьд өмнө судлагдаагүй, эсвэл маргаантай байгаа олон чухал асуудлыг судлан шийдвэрлэхэд багагүй хувь нэмэр



*Академич Д.Төмөртоого, академич Ш.Бира нар*

оруулдгийг монгол судлаач эрдэмтэд зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг. Тэрбээр өмнөхөө давтахгүйгээр өнөөгийн судалгааг ганц шат боловч ахиулахыг л гол зорилгоо болгож чармайн ажилладаг ажээ.

Профессор Д.Төмөртоого багш Улаанбаатар хотноо зохиогддог Олон улсын монголч эрдэмтний II-XI их хурал, “Монголын нууц товчоон”-ы 750 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал болон Англи, Герман, Тайвань, Турк, Энэтхэг, Япон улсад болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд нийтдээ 80 удаа илтгэл тавьж, наран ургахуй дорно зүгийн Япон, Тайвань, Өмнөд Солонгос, Хятадаас наран шингэхүй өрнө зүгийн Австри, Америк, Англи, Герман, Франц, Швейцар зэрэг оронд богино, урт хугацааны албан томиллолтоор очиж, ертөнцийг ухаарч, мэдлэг нь улам улмаар гүнзгийрэн өргөжсөн байна. Академич

Д.Төмөртогоо багш Анкара, Берлин, Блүүмингтон, Бонн, Будапешт, Бээжин, Вена, Истанбул, Киото, Күнмин, Лондон, Москва, Осака, Сөүл, Тайпей, Токио, Торонто, Улаанбаатар, Хөххот, Шинэ Дели зэрэг хотноо зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож, лекц уншиж, илтгэл хэлэлцүүлсэн байдаг.



*Академич Д.Төмөртогоо, доктор Э.Пүрэвжав нар*

Профессор Д.Төмөртогоо гадаадын олон оронд удаан жилээр багшилж, олон улсын Монгол судлалын хөгжилд бүтээлч хувь нэмрээ оруулсан нэрт эрдэмтэн болно. Профессор Д.Төмөртогоо багш 1971-1974 онд Энэтхэгийн Шинэ Дели хотын Ж.Неругийн нэрэмжит их сургуулийн Төв Ази - Хималайн судлалын институт, 1975-1977 онд Японы Токиогийн Гадаад судлалын их сургууль, 1989-1993 онд ХБНГУ-ын Бонны их сургуулийн Төв Азийн хэл, соёл судлалын хүрээлэнд зочин профессороор уригдан үр бүтээлтэй ажиллаж, Монгол судлалын хойч үе болсон залуу халааг сургаж бэлтгэхэд тодорхой

хувь нэмрээ оруулж, дэлхийн монгол судлалд данстай профессор болжээ.

Академич Д.Төмөртогоо бол дэлхий дахины монголч эрдэмтдийн дунд өөрийн гэсэн тогтсон арга барил, үзэл бодолтой, өөрийн гэсэн чиглэсэн жанжин шугам, байр суурьтай эрдэмтэн юм. Түүний эрдэм шинжилгээний ажлын “онолын гол баримтлал нь хэлний бүтэц - тогтолцоот чанар мөн” бөгөөд академич Ш.Лувсанвандан (1910-1983) багшийнхаа судалгааны дэг сургуулийг тууштай дагаж, бүтээлчээр үргэлжлүүлэгч мөн.

Монгол улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн Д.Төмөртогоо багшийн сургалт, судалгааны үйл ажиллагааг төр засаг, боловсрол, шинжлэх ухааны төв байгууллагуудаас өндрөөр үнэлж, “Ардын боловсролын тэргүүний ажилтан”, “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”, “Алтан гадас” одон (1997), академич Б.Ринчений нэрэмжит медаль, “Үндэсний бичиг, соёлыг дэлгэрүүлэгч” тэмдэг, ШУА-ийн дээд шагнал “Хубилай хаан” алтан медалиар шагнаж, 2002 онд Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээжээ.

Ардын уран зохиолч, туульч өөлд Тангадын Галсан 1998 онд тэрлэн бичиж ШУА-ийн “Эрдэм” сонин (1998 оны хоёрдугаар сар, № 3)-д нийтлүүлсэн “Эрдэмтэд өргөх инээдмийн хадаг” хэмээх нөхөрсөг шогийнхоо академич Д.Төмөртогоод тусгайлан зориулсан хэсэгт:

*Бага сургуульд багшлах гэхээр  
Багадаад болдоггүй  
Их сургуульд багшлах гэхээр  
Ихдээд болдоггүй  
Умар, өрнө, дорнын гүрэн  
Уриад болдоггүй  
Улсын багшийн дээд сургуулиас  
Нүүр буруулдаггүй*





*Төмөрөө багш тавь хүрсэн ч  
Хорин тавтын золбоотой  
“Түүхэн хэл зүй”-н ухаанд бол  
Монгол талдаа манлай  
Эрдэм шүтээнтэй академич таныг  
Бурхан өршөө!  
Эрдэнээс үнэтэй алтан цагий нь  
Гоо бүсгүй ч бүү хороо!*

хэмээн элэглэл шүлэг тэрлэн зохиосон байдгийг дурдмаар санагдлаа.

Академич Д.Төмөртоогоо багш маань ясны эгэл даруухан, эерүү соёлч харьцаатай, ямар ч хүнд эерэг сайхан сэтгэгдэл үлдээж чаддаг, туйлын залуу сэтгэлгээтэй, үнэхээрийн цэвэр цэмцгэр, хаа ч биеэ эзэмдэн зөв авч явах нь үлгэр жишээ, аливаа хүнийг нас, бие, хүйс, эрх мэдлээр нь дэслэн эрэмбэлж харьцдаггүй, нас бие тэгширсэн хөвгүүд охидтой яралтал инээж, тоглоом наадмын үгсийг шидэлцэн хөгжилдөж байхыг нь харахад бахархмаар байдгийг онцлон тэмдэглэе. “Их мөрөн дөлгөөн, эрдэмт хүмүүн даруу” гэдэг энэ буюу.

Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Б.Ринчений нэрэмжит

шагналт, ШУА-ийн жинхэнэ гишүүн, хэл бичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Бичээч овогт Домийн Төмөртоогоо багш бол үндэсний шинжлэх ухаан, дээд боловсролын байгууллагад олон жилийн турш хоёргүй сэтгэлээр үр бүтээлтэй ажиллаж, Монгол хэл бичгийн ухаан, монгол хэл шинжлэлийн чиглэлээр судалгааны дорвитой шилдэг бүтээлүүд туурвин бичиж, олон улсын Монгол судлалыг урагшлуулан хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байгаа эрин үеийн нэрт эрдэмтдийн нэг мөн билээ.

*Хэл бичгийн ухааны доктор  
дэд профессор Э.Пүрэвжав*